

## ХЯТАДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ИМПОРТЫН ХАМААРАЛ

Б.Отгонбаатар\*

### Товч утга

**Э**нэхүү өгүүлэл нь Хятадын эрчим хүчний аюулгүй байдлын судалгааны голлох арга зүй, онолын суурь маргаан, судлаачдын байр суурийг харьцуулан авч үзэж, Хятадын эрчим хүчний салбарын дотоод нөхцөл байдал болон гадаад бодлогын нарийн төвөгтэй хамаарлыг тайлбарлах багахан оролдлого юм. Энэ хүрээнд БНХАУ-ын импортын хамаарлаа багасгах, эрчим хүчний аюулгүй байдлын орчноо сайжруулахаар зорьж буй бодлого, стратегийг аль нэг онолын тайлбарт шууд автахгүйгээр, тэнцвэртэй, цогцоор нь судлан ойлгоход тустай 4 гол үйл ажиллагааны чиглэлийг мөн онцлон нэрлэж байгаа юм.


**Түлхүүр үг:** газрын тос, гадаад бодлого, аль Хятад нь вэ?

Газрын тос, нүүрс, байгалийн хий, сэргээгдэх эрчим хүч зэрэг бүхий л эх сурвалжийг нэгтгэн тооцсон судалгаагаар 2012 онд Дэлхийн Эрчим Хүчний Нийт Хэрэглээний 21,3%-ийг БНХАУ дангаар хэрэглэжээ.<sup>1</sup> Өмнө нь олон жил уг үзүүлэлтээр дэлхийд тэргүүлсэн АНУ-г БНХАУ 2010 онд ардаа орхин дэлхийн хамгийн их эрчим хүч хэрэглэгч орон болсон байна.

Зарим нэг голлох статистик мэдээллийг үндэслэвэл Хятадын эрчим хүчний хэрэглээний өсөлт цаашид ч үргэлжлэх хандлагатай байна. Тухайлбал Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг (IEA) болон Бритиш Петролеум (BP) зэрэг дэлхийн томоохон судалгааны төв, компаниудын тооцоноор хэрэв өнөөгийн технологийн чадавхи, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад болон улсынх нь эрчим хүчний бодлогод томоохон өөрчлөлт гарахгүй бол Хятад, Энэтхэг хоёрын эрчим хүчний хэрэглээний нийлбэр нь 2030 он гэхэд дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний 35% орчим болох ба түүний дотор Хятадад 27% орчим<sup>2</sup> нь ноогдох магадлалтай гэжээ.

\*Б.Отгонбаатар - Васеда их сургуулийн докторант

## Дэлхийн эрчим хүчний хэрэглээ - 2011 он (улс орноор)



Хүснэгт 1

Өнөөдөр ч нийт дэлхийн эрчим хүчний хэрэглээний 1/5-г нэг улс дангаар хэрэглэж байгаа нь олон улс орны анхаарлыг Хятадын эрчим хүчний салбар дээр зүй ёсоор татахын зэрэгцээ, Хятадын засгийн газрыг ч жил ирэх бүр өсч байгаа хэрэглээгээ хэрхэн дотоодын болон гадаадын хязгаарлагдмал нөөцөөр тогтвортой хангах вэ гэдэг ихээхэн хүнд сорилтод оруулж байгаа<sup>3</sup> юм. Тэр тусмаа эрчим хүчийг үйлдвэрлэх түүхий эд гэдэг бол жижиг том гэлтгүй дэлхийн аль ч орны хувьд стратегийн хамгийн чухал бүтээгдэхүүнд тооцогддог бөгөөд хамгийн ихээр “улс төрждөг” бүтээгдэхүүн ч гэж цоллогдох нь бий.

Ийм нөхцөлд Хятад нь эдийн засгийн тэлэлт, хурдтай өсөлтөө хэрхэн, хаанаас, яаж, ямар эх үүсвэрийн эрчим хүчээр хангах бол? гэдэг дан ганц Хятадын дотоод хэргийн асуудал бус дэлхийн эдийн засаг, улс төрийн бүхий л томоохон улс орнуудтай шууд хамааралтай өргөн ач холбогдолтой сэдэв болж байна. Тэр дундаа олон улсын харилцааны түүхэнд газрын тос бол дэлхийн нийгэм улс төр, цэрэг эдийн засгийн хамгийн гол сэдэв, халуун цэгүүдийн нэг байсаар ирсэн билээ.

Орчин үеийн дэлхийн түүхэнд газрын тосны салбарт хямрал үүссэнээр улс орны бусад олон олон салбар төдийгүй олон улсын цэрэг, улс төрийн харилцаанд хүртэл хүндрэлтэй байдал үүсгэсэн баримт нилээд бий. Маш товчоор тоймловол 1960-70 онуудад Франц, Япон зэрэг шинээр аж үйлдвэржсэн улс орнууд эдийн засгийн хөгжлөөрөө өнөөгийн Хятад, Энэтхэг шиг цойлон гарч ирж, дэлхийн нефтийн хэрэглээнд шинэ тэнцэтгэл үүсгэн, улмаар

нийлүүлэлтийн хомсдол, үнийн хөөрөгдөл үүссэн байдаг. Харин тухайн үеийн гол үйлдвэрлэгч орнууд болох Герман, Канад, АНУ-ын газрын тосны үйлдвэрлэл нь мөн ойролцоо нэгэн цаг үед хамгийн дээд цэгтээ хүрч, улмаар Израйл-Палестины зөрчлөөс үүдэн Арабын хойгийн орнууд улс төрийн зорилгоор нефтийн нийлүүлэлтэндээ “эмбарго” хориг тавьснаар 1973 онд дэлхийн газрын тосны анхны хямрал үүссэн түүхтэй. Чухам энэ цаг үеэс дэлхийн олон улс орнууд газрын тосны стратегийн нөөц дотооддоо бэлтгэж, эрчим хүчний гадаад харилцаа олон улсын харилцааны чухал сэдэв болжээ. 1973 оны хямрал бүхэлдээ дэлхийн эдийн засгийг хямралд оруулж, олон улсын улс төрийн орчинг тогтворгүй байдал руу түлхсэн байдаг. Гэвч хоёр дахь нь ердөө зургаахан жилийн дараа буюу 1979 онд Иранд шашны хувьсгал өрнөснөөр дэлхийн газрын тосны нийлүүлэлтэнд хомсдол үүсэн хямрахад хүргэжээ. Улмаар 1990 онд Ирак Кувейт рүү халдсанаар удаах хямралын давалгааг бий болгосон бол, хамгийн сүүлийн тод жишээ нь 2003 онд эхэлсэн Иракийн хоёрдугаар дайн ба уг дайны үүслийг ямар нэгэн байдлаар газрын тостой холбон тайлбарлах нь олонтой. Эдгээрээс гадна ердөө сүүлийн хэдхэн жилд Африк, Ойрхи Дорнодын олон олон оронд өрнөж буй цэрэг улс төрийн дэглэмээ эсэргүүцсэн хөдөлгөөн, дотоод зөрчлүүд газрын тосны баялаг ихтэй орнууд, бүс нутагт өрнөж байгаа нь “тохиолдлын” зүйл биш болов уу. Тэдгээр зөрчилдөөний ард ч газрын тосны улс төрийн жин нөлөө тодорхой түвшинд байхыг үгүйсгэхгүй. Эдгээр зөрчлийн нөлөө аль хэдийнэ газрын тосны олборлолт, нийлүүлэлт, тээвэрлэлт, борлуулалтанд нөлөөлж дэлхий дахинд “хар алтны” үнэ нь өсөж буй нь бодит байдал боллоо.

Харин XXI зууныг манлайлна гэгддэг өнөөгийн Хятадын эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээний тухай, судлаач Давид Звейг хэлэхдээ Бээжингийн хувьд нэг намын системээ аль болох урт хугацаанд хэвээр нь үргэлжлүүлэхэд эдийн засгийн хөгжлөөр иргэдийнхээ амьдралыг дээшлүүлнэ гэдэг юу юунаас ч илүү хамгийн том зорилт. Ийм нөхцөлд эдийн засгийг нь дэмжих эрчим хүчний тогтвортой нийлүүлэлт хамгаас чухал<sup>4</sup> гэсэнтэй Peak Oil буюу дэлхийн газрын тосны нөөц эцэслэгдэх ойртож байгаагийн хэрээр улс хоорондын зөрчил ихсэх хандлагатай гэсэн үзэл санааг хамтатган авч үзвэл Хятадын эрчим хүчний улам бүр өсөж буй хэрэгцээг найдвартай хангана гэдэг ямар их зөрчилдөөнт шинж чанартай зорилт болохыг тодорхой харж болно. Энэ утгаараа тус салбар дахь Хятадын гадаад бодлого, стратегийг ойроос ажиглаж буй судлаачдын дунд уламжлалт реалист онолын чиг хандлагаар

## Хятадын эрчим хүчний аюулгүй байдал ба импортын хамаарал

асуудлыг голлон тайлбарлах нь хандлага хүчтэй оршсоор байгаа юм. Гэхдээ угаас нүүрсний дотоод баялаг ихтэй Хятадын хувьд газрын тос бол хамгийн гол импортоос хамааралтай, бодлого боловсруулагчдын “толгойны өвчин” болж буй эрчим хүчний эх үүсвэр нь<sup>5</sup> юм.

1993 онд Хятад газрын тосны бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл нь гадаад эх үүсвэрээс нийлүүлэгдэж байсан хэмжээнээс анх удаа давсан бөгөөд жил тутам хурдтай өссөөр яг 20 жилийн дараа буюу энэ 2013 оны 4 сард БНХАУ дэлхийн газрын тосны хамгийн том импортлогч орон боллоо.<sup>6</sup> Хэдийгээр АНУ газрын тосны хамгийн их хэрэглэгч орон хэвээрээ байгаа ч дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал нь Хятадаас илүү учир Хятад газрын тосны хамгийн том импортлогч оронд тооцогдох болов. Хүснэгт 2-оор харуулж буй 2001-2011 оны хоорондох 10 жилийн хугацаанд гэхэд Хятадын нефтийн хэрэглээ импортын хамаарал руу улам бүр орж албан ёсны мэдээгээр 2001 онд газрын тосны хэрэглээний 68 хувийг дотоод нөөцөөрөө хангаж байсан бол 2011 оны байдлаар 42 хувь болтлоо буурсан байна. Хэдийгээр хараахан албан ёсоор тоо баримт нь нэгтгэгдэн нийтийн хүртээл болоогүй байгаа ч АНУ-ыг ардаа орхин Хятад дэлхийн хамгийн том газрын тос импортлогч орон болсон гэсэн дээрхи Уолл Стрийт Журналын мэдээнээс үзвэл Хятадын газрын тосны импортын хамаарал 2012, 2013 онд ч мөн үргэлжлэн өсчээ.


### Хятадын нефтийн хэрэглээ 2001

■ Дотоод үйлдвэрлэл ■ Импорт



### Хятадын нефтийн хэрэглээ 2011

■ Дотоод үйлдвэрлэл ■ Импорт



Хүснэгт 2

Судлаач Андрьюс Спийд Хятадын эрчим хүчний салбарын өнөөгийн онцлогийг тодорхойлохдоо хэдийгээр гадаадын олон судлаачид тус салбарын Хятадын төрийн албаны мэдээлэл нь хаалттай нууцлаг, ойлгон судлахад төвөгтэй гэж бичдэг ч бодит байдал дээр хэтэрхий их мэдээлэл байгаад, харин түүнийг дагаж ойлгох ойлгоц нь хоцорч байгаа<sup>7</sup> тухай шүүмжлэл дэвшүүлсэн байдаг. Бодит байдал дээр чухам ямар онолын чиг хандлагаар Хятадын эрчим хүчний бодлого, хамаарах дотоод болон гадаад

хүчин зүйлсийг судлах вэ гэдэг дээр өнөөдөр судлаачид тодорхой нэгдсэн ойлголтонд хүрч чадаагүй буюу уг сэдвийн судалгаа өрнөж буй шинэ үйл явдал, алхамууд, ялангуяа Хятадын засгийн газрын бодлогын хүрээг судлан таних, тайлбарлан ойлгох хүрээнд ид өрнөж байгаа судалгааны чиглэл гэж хэлж болохоор байгаа юм.

Мөн дээр дурьдсанчлан өнөөг хүртэл хамгийн хүчтэй явж ирсэн Реалист чиглэлийн гол хандлага нь судлаач Уэстэйн Норэнгийн маш энгийнээр тодорхойлсоноор аливаа орны улс төрийн лидерүүд бол газрын тосыг гутал, элетрон бараа, авто машинаас маш өөр ангиллаар хардаг төдийгүй түүнийг зах зээлийн өөрийн зохицуулалтанд даатган үлдээнэ гэдэг бол байж боломгүй зүйл юм<sup>8</sup> гэж үзсэн бол Ричард Руоскранс зэрэг Либерал үзлийн төлөөлөгчид яг тэдний эсрэгээр буюу эрчим хүчний бүтээгдэхүүн бол хувцасны загварын моод, автомашин гаднаас худалдаж авахаас онцын ялгаагүй үйл явц<sup>9</sup> гэж үзэж байжээ. Мөн түүнчлэн судалгааны хандлагын тухайд Хятадын эрчим хүчний бодлого судлалын чиглэлд шинэ үеийн хүчтэй төлөөл болж буй Эрика Доунсын судалгааны арга зүй нь хуучин реалист болон либерал онолыг харьцуулах бус оронд нь эдийн засгийн үндсэрхэг хандлага – эдийн засгийн либерал хандлага<sup>10</sup> гэсэн ангиллаар ялган гол асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэсэн байр суурьтай. Түүний дотор төрийн оролцоотой эрчим хүчний үндэсний компаниудын гадаад дахь үйл ажиллагаа, тус салбарын төрийн зохицуулалт зэрэг бол энэ чиглэлийн судалгаа хийгчдийн хамгийн гол “судалбар” буюу цаашдын шинэ судалгааны гол анхаарлаа хандуулах талбар гэж хэлж болохоор чухал орон зай юм.

Нэртэй Хятад судлаач Кэннэт Либердаль тэргүүтэй дотоодын шийдвэр гаргах механизмыг нь чухалчилдаг “тархмал эрх мэдэл”<sup>11</sup> –ийн онолын чиглэлийнхэн Хятадын эрчим хүчний салбарын шийдвэр гаргалт нь зарим ээдрээтэй асуудлуудлыг шийдвэрлэхэд нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоо тухайн шийдвэрт тусгагдах, эсвэл хамаарах төрийн нэгжийн тус тусын онцлогтой байгууллагын “хавчигдмал” байр суурь нөлөөлж явсаар дээрээс доошоо бус олон оролцогчийн эрх ашиг тусгагддаг, дотроо өрсөлдөөнтэй салбар<sup>12</sup> гэж тайлбарласан байдаг бол уг онолын чиглэлийг өнөө цагт шинэ шатанд гаргаж буй судлаачдын нэг Чэн Ли: Мао, Дэнг нарын үеийнхтэй адил хүчтэй эрх мэдэлтэй нэг лидерийн дор шийдвэр гаргах үйл явц хэвээрээ явахгүй байгаа бөгөөд өөр өөр байр суурьтай олон сонирхлын бүлэг болон эрчим хүч мэт аль нэг аж үйлдвэрийн гол салбарын хүчтэй бүлэглэлийн нөлөөнд ямар нэг шийдвэр нөлөөлөгдөх магадлал өндөрсөн<sup>13</sup> гэж үзэж байгаа

## Хятадын эрчим хүчний аюулгүй байдал ба импортын хамаарал

юм. Харин яг түүний эсрэг буюу харьцангуй “уламжлалт” гэж хэлж болох байр суурийг Иан Тайлор өнөөгийн Хятадын эрчим хүчний хүрээндэх шийдвэр гаргалтын тухайд авч үзэхдээ дараах байдлаар илэрхийлсэн байна. Хэдийгээр төрийн өмчит том компаниудын олон улсын байр суурь бэхжиж, өөрсдийн эрх ашгийн төлөө төрийн бодлогод ямар нэг шахалт үзүүлэх боломжтой болж байгаа хэдий ч тэд төв засгийн газрын яамдууд төдийгүй аймаг хотын захиргааны гээд бүхий л шатны төрийн байгууллагын бодлогод хүндэтгэлтэй, анхааралтай хандах нь тэдний ашигтай ажиллах үндсэн хүчин зүйл хэвээр байсаар байгаа<sup>14</sup> тухай онцолсон байна.

### **ДҮГНЭЛТ**

Хятадын эрчим хүчний бодлогыг дан ганц уламжлалт реалист-либерал чиглэл, аль эсвэл Доунсын тодорхойлсон эдийн засгийн үндсэрхэг хандлага – эдийн засгийн либерал хандлага зэргийн аль нэг нь бүхэлдээ зөв мэтээр харах нь учир дутагдалтай харагдаж байгаа ба тэдгээр онолын суурь маргааныг чухам аль Хятад нь вэ, хаана хэрэгжүүлж буй ямар стратеги нь бодлого нь вэ? гэх мэт илүү нарийвчилсан, хэсэгчилсэн судалгаагаар баяжуулах, бүрхэг ойлголтуудыг тодруулах ажил өнөөгийн нугсэдвээр судалгаа хийгчдийн гол анхааралын төвд явж байгаа дүр зураг харагдаж байна. Өмнө нь дурьдсанчлан Хятадын төрийн систем, эрчим хүчний салбарын дотоод өөрчлөлт шинэчлэл, олон улсын байдал, технологийн дэвшил зэрэг гол гол үйл явцын нарийн уялдаа холбоог харгалзахгүйгээр “хоосон” онолын маргаан өрнүүлэх, тэдгээр маргааныг шууд авч хэрэглэх зэрэг нь асуудлын мөн чанарыг бодитойгоор тайлбарлах, дүгнэхэд хүндрэл үүсгэж, төөрөгдөл үүсгэх муу талтай мэт.

Иймээс сүүлийн жилүүдэд Хятадын импортын хамаарлаа багасгахын тулд хийсэн үйл ажиллагааны гадаад дотоод аль аль хүчин зүйлсийг нь харгалзан үзсэн дараах 4 гол стратегийнх нь хүрээнд Хятадын эрчим хүчний бодлого, авч хэрэгжүүлж буй алхамыг нь нягтлан шалгах, онолын тайлбаруудыг нь харьцуулан авч үзвэл илүү оновчтой байж болох юм. Тэдгээр нь 1. Импортын эх үүсвэрээ олон түвшин, сувагтай болгох чиглэлд хийсэн цогц алхмууд 2. Дотоод нөөцөө ашиглах, хэрэглээг багасгах оролдлогууд 3. Төрийн байгууллагын зохион байгуулалт, удирдлагын хангалтыг сайжруулах шинэчлэлүүд 4. Тээвэрлэлтийн замыг нэмэх, бататгах, хамгаалах чиглэлүүд тус тус болно. Мэдээжийн хэрэг судлаач бүр судалгааны гол анхаарлаа хандуулах хүрээ, хариулт өгөхийг зорьж буй асуултын онцлогос хамааран олон төрлийн судалгааны арга зүй баримтлаж

болох ч Хятадын дотоод болон гадаад орчин нөхцлийг зэрэгцүүлэн авч үзэж, улмаар харьцангуй “тэнцвэртэй” ойлголт дээрээ үндэслэн Хятадын эрчим хүчний бодлогын гадаад харилцаа, хилийн чанад дахь стратеги алхам зэргийг нь судлах нь илүү үндэслэлтэй арга зүй, судалгааны хандлага байж болох талтай.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

- <sup>1</sup> (BP Statistical Review of World Energy June 2012)
- <sup>2</sup> (British Petroleum World Energy Outlook 2030 Jan 2012)
- <sup>3</sup> (Yergin 2011)
- <sup>4</sup> (Zweig and Jianhai September/October 2005)
- <sup>5</sup> (Daojiong 2006)
- <sup>6</sup> <http://online.wsj.com/article/SB10001424127887323646604578400410832143602.html>
- <sup>7</sup> (Andrews-Speed 2010)
- <sup>8</sup> (Noreng 2002)
- <sup>9</sup> (Rosecrance 1986)
- <sup>10</sup> Economic Nationalist Approach Vs. Economic Liberal Approach
- <sup>11</sup> A Fragmented authoritarianism model
- <sup>12</sup> (Lieberthal and Oksenberg 1988)
- <sup>13</sup> (Li 2011)
- <sup>14</sup> (Taylor 2009)

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Andrews-Speed, P. Energy Security in the Gulf. Challenges and Prospects. Abu Dhabi: Emirates Center for Strategic Studies and Research, 2010.

“BP Statistical Review of World Energy.” June 2012.

“British Petroleum World Energy Outlook 2030.” London, Jan 2012.

Daojiong, Zha. “China’s Energy Security: Domestic and International Issues.” Survival, 2006: 179-190.

Li, Cheng. China’s Midterm Jockeying: Gearing Up for 2012 (Part 4: Top Leaders of Major State-Owned Enterprises). Brookings Institution, 2011.

Lieberthal, Kenneth, and Michel Oksenberg. Policy Making in China: Leaders, Structures, and Processes . Princeton, New Jersey: Princeton University Press, 1988.

Noreng, Шыстеин. Crude Power . London: I.B. Tauris, 2002.

## Хятадын эрчим хүчний аюулгүй байдал ба импортын хамаарал

Rosecrance, Richard. The Rise of the Trading State: Commerce and Conquest in the Modern World. New York: Basic Books, 1986.

S.Downs, Erica. "Business Interest Groups in Chinese Politics: The Case of the Oil Companies." In China's Changing Political Landscape: Prospects for Democracy, by Cheng Li, 121-141. Washington, DC: Brookings Institution Press, 2008.

S.Downs, Erica. "The Fact and Fiction of Sino-African Energy Relations." China Security, Summer 2007: Vol. 3 No. 3, 42 - 68.

Taylor, Ian. China's New Role in Africa. Colorado, Boulder: Lynne Rienner Publishers, 2009.

Yergin, Daniel. The Quest: Energy, Security and The Remaking The Modern World. New York : The Penguin Press, 2011.

Ziegler, Charles E. "The Energy Factor in China's Foreign Policy." Journal of Chinese Political Science, Spring 2006.

Zweig, David, and Bi Jianhai. "China's Global Hunt for Energy." Foreign Affairs, September/October 2005: 25-38.

### **Abstract**

The paper is attempted to analyze and to compare the mainstream approaches, relevant theoretical debates, prominent scholar's positions on Chinese energy security discussions. By offering 4 special areas of focus, the paper also seeks to provide insights for researchers in order to understand a nexus between domestic factors and China's foreign policies in energy field with sound and balanced approach.

**Key words:** oil, foreign policy and which China?